



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/74

Цагаан-Уул сум

Г Урьдчилан сэргийлэх арга хэмжээ Г
авах тухай ,

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.14, 59 дүгээр зүйлийн 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд мал амьтаны халдварт, гоц халдварт, шимэгчтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухайн өвчний тархвар зүй, голомтын судалгаанд үндэслэн 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2024 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр хүртлэх хугацаанд үр дүнтэй зохион байгуулахыг мал эмнэлгийн тасгийн дарга Улсын байцаагч (Т.Чандмаа), (Багийн Засаг дарга) нарт тус тус үүрэг болгосугай.

2. Мал сүргийг халдварт, гоц халдварт, шимэгчтгэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд голомт бүхий газар нутагт байгаа сүргийг бүрэн хамруулсан эсэхэд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга Улсын байцаагч (Т.Чандмаа)-д хариуцуулсугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-т даалгасугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ



/Zahiramj 2024/